



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 9 сарын 12 өдөр

Дугаар 302

Улаанбаатар хот

Нэр бүхий 3 үнэт цаасны компанийн үнэт цаасны
дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1 Энэхүү тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий үнэт цаасны компаниудын үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Үнэт цаасны компаниудын үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж олон нийт, харьяалах татварын алба болон Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны
9. дүгээр сарын 12-ны өдрийн 302 дугаар
тогтоолын хавсралт



№	Компанийн нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл
1	“Гранд девелопмент ҮЦК” ХХК	5455022	Дилер
2	“Дархан брокер ҮЦК” ХХК	2024144	Дилер
3	“Санар ҮЦК” ХХК	2088991	Дилер